

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ГЭР, ХАШАА БАЙШИНГИЙН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Гэр, хашаа, байшин					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Галын 2. Байгалийн 3. Цахилгаан эрчим хүчний 4. Гадны нөлөөллийн					
	Даатгалын нэмэлт эрсдэл	1. Хулгай дээрмийн					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Үндсэн эрсдэл: 1.0-2.5%,		Нэмэлт эрсдэл: 0.5-1.0%			

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ**

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Жижиг хулгай, учир битүүлгээр алга болох /ямар нэг баримт нотолгоогүй/
3. Эд хөрөнгийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, зэврэлт, исэлдэл ууршилт, алдаатай эх сурвалж, далд дефект, үйлдвэрийн гэмтэл зэрэг тухайн хөрөнгө, бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол, гэмтэл.
4. Даатгуулагч гал, эрчим хүч, ус, дулаан, цахилгаан, сантехник ашиглалт, аюулгүй ажиллагааны ашиглах дүрэм, заавар, стандарт зэрэг хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хохирол,
5. Үйлдвэрлэл буюу барилгын ажлын дефекттэй холбоотой үйл ажиллагааны болон ур хийцийн алдаа, алдаатай зураг төсөл, зөвшөөрөлгүй шинэчлэн боловсруулсан барилгын зураг төсөл;
6. Хөрөнгийн даатгалтай холбоогүй эрсдэл, даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон тохиолдол;
7. Шалгаагүй ба баталгаажуулаагүй технологи ашигласан, шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
8. Даатгалын зүйлийн баталгаат хугацааны аливаа эвдрэл гэмтэл, хохирол;

9. Хөрсний суулт, агаар мандлын бохирдолт, мөөгөнцөрт идэгдэх, өвс ургамал, шавьж хорхой, шимэгчдийн үзүүлсэн нөлөө болон цагийн урсгалаар үзүүлдэг бусад хүчин зүйлүүд даатгалын эрсдэл үүсгэх нөхцөл орчин болсон. Мөн тухайн хөрөнгийн шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;
10. Засгийн газар, эсвэл шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, төрийн захиргааны болон олон нийтийн байгууллага, эрх бүхий хуулийн этгээдийн гаргасан шийдвэрээс үүдсэн хохирол;
11. Хөрөнгийг, түүний зарим хэсгийг засаж залруулах, орлуулахтай холбогдон гарах зардал:
  - 11.1 Буруу материал ашигласан эсвэл буруу хийсэн;
  - 11.2 Ашигласан загвар дизайн, төсөл, төлөвлөгөө, онцлогийг алдаж тооцсон;
12. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан, даатгалын тохиолдол болох орчин нөхцөл бүрдүүлсэн;
13. Дайн, зэвсэгт бослого, дотоодын үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
14. Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого мөн асбестос бодис ашигласнаас учирсан хохирол;
15. Буруутай этгээдээс хохирол шаардах эрхээсээ татгалзсан эсхүл шаардах боломжгүй болгосон;
16. Хүндэтгэх шалтгаангүйгээр нөхөн төлбөрийн материалыг гэрээнд заасан хугацаанд бүрдүүлж өгөөгүй эсхүл гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлээгүй.
17. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.